



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/03

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дүгээр зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 45 дугаар зүйлийн 45.2, 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1, 46.1.4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2017 оны шатахуун, бичиг хэрэг, зөөлөн эдлэл нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ж.Гантулга	-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Д.Цэцэгсүрэн	-Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүн:	Ц.Ганчимэг	-Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Хоёр. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ж.Гантулга/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

03 006